



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 02 сарын 31 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Гэрээний загвар батлах тухай

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Засгийн газрын 2016 оны 295 дугаар тогтоолоор батлагдсан “Аудит хийх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эрчим хүчний аудитын гэрээ”-ний загварыг хавсралтын ёсоор баталсугай.
2. Батлагдсан гэрээний загварыг эрчим хүчний аудиторууд, үүрэг хүлээсэн хэрэглэгчдэд таниулан, чиглэл өгч ажиллахыг Эрчим хүч хэмнэлтийн газар /Ц.Атаржаргал/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын алба /Г.Эрхэмбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



А.ТЛЕЙХАН


ЗОХИЦУУЛАГЧ

Д.БАССАЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

Эрчим хүчний зохицуулах хорооны
2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн
96 дугааар тогтоолын хавсралт



ЭРЧИМ ХҮЧНИЙ АУДИТЫН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

Улаанбаатар хот

... оны ...-р сарын ...

Монгол Улсын Иргэний хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 295 дугаар тогтоолоор батлагдсан “Аудит хийх журам”-ыг тус тус удирдлага болгон нэг талаас Монгол Улсын аж ахуйн нэгжийн бүртгэлийн дугаар гэрчилгээтэй, регистрийн дугаартай (байгууллагын нэр, хэлбэрийг бичнэ)(цаашид “**ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ**” гэх) түүнийг төлөөлж (нэр, албан тушаал), нөгөө талаас дугаар магадлан итгэмжлэл бүхий аудитын байгууллага (цаашид “**ГҮЙЦЭТГЭГЧ**” гэх), түүнийг төлөөлж (нэр, албан тушаал) нар, эсвэл дугаар аудитын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий гэрчилгээтэй аудитор (овог, нэр) нар (цаашид хамтад нь “**ТАЛУУД**” гэх) дараах нөхцлүүдийг харилцан тохиролцож **20..** оны ... дугаар сарын ... –ны өдөр энэхүү эрчим хүчний аудитын гэрээ (цаашид “**ГЭРЭЭ**” гэх)-г байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

1.1. Энэхүү гэрээгээр аудитын ажлын хүрээ, тооцооны аргачлал, хэмжилтийн багаж хэрэгсэл, аудитын үйлчилгээний хөлс, гүйцэтгэх, үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа, аудитын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулна.

Хоёр. Ерөнхий нөхцөл

2.1. Гэрээтэй холбоотой аливаа эрх, үүрэг, хариуцлагыг гэрээлэгч талууд бүрэн хариуцна.

2.2. Гэрээний загварт заагаагүй талуудын эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой бусад асуудлыг Монгол Улсын хууль, тогтоомжид нийцүүлэн талууд харилцан тохиролцож тусгаж болно.

Гурав. Аудитын үйл ажиллагаа

3.1. Аудитын үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

3.2. Талууд аудит хийх төлөвлөгөөг хамтран боловсруулах ба төлөвлөгөө нь энэхүү гэрээний хавсралт болно.

3.3. Төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгана.

3.3.1. Аудитын хамрах хүрээ /аудит хийх барилга байгууламж, технологийн шат дамжлага, тоног төхөөрөмжийн жагсаалт, ажлын нийт эзэлхүүн/